



МОНГОЛ УЛСЫН ГЭГЭЭРЛИЙН САЙДЫН ТУШААЛ

2000 оны 9 сарын 1 ны өдөр

Дугаар 201

Улаанбаатар хот

Гадаадад суралцуулах тухай

ТУШААХ НЬ:

1. Алтанхуяг овогтой Гэрэлтуяаг хүн ам зүйн чиглэлээр Австрали улсын Үндэсний Их сургуулийн докторантурт, Жигжид овогтой Ганбат, Дүнхэр овогтой Батмөнх нарыг санхүү, эдийн засгийн чиглэлээр АНУ-ын Колорадогийн Их сургуулийн магистрантурт тус тус 2 жилийн хугацаагаар 2000-2001 оны хичээлийн жилээс эхлэн суралцуулсугай.

2. Гэгээрлийн сайд, Сангийн сайдын 1998 оны 67/131 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй орнуудын магистрантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчтай гэрээ байгуулж, холбогдох төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Б.Ганбат/-д, энэхүү тушаалын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Д.Мөнхжаргал/-т тус тус даалгасугай.

САЙД

А.БАТТӨР

